



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

**2022 I-IV**

## ГАРЧИГ

<b>1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ .....</b>	<b>1</b>
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл .....	1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл .....	1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого.....	3
<b>2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР .....</b>	<b>4</b>
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл.....	4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар .....	4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар.....	4
2.1.3. Газрын тосны салбар.....	4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн .....	7
<b>3. ГАДААД ХУДАЛДАА .....</b>	<b>8</b>
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт .....	8
3.1.1. Уул уурхай, олборлох салбар .....	8
3.1.2. Газрын тосны салбар.....	10
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар.....	10
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	11
3.2.1. Газрын тосны салбар.....	11

## 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

### 1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан **МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР** Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ (БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
			Төлөвлөгөө	I-IV		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	36,700.0	3,791.4	32,908.6	10.3%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,212.9	469.3	743.6	38.7%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	9,486.8	1,017.4	8,469.3	10.7%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) <sup>1</sup>	тн	20.0	3.8	16.2	19.0%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	6,280.1	-	6,280.1	0.0%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>2</sup>	мян.тн	134.0	40.7	93.3	30.3%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх <sup>3</sup>	мян.тн	896.3	77.4	818.9	8.6%

Эх сурвалж: СЯ, ГЕГ, МБ

### 1.2. ТӨСӨӨТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2022 оны эхний 4 сарын байдлаар 5,269.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 417.9 тэрбум төгрөг буюу 8.6 хувиар өссөн байна.

Үүнээс, Эрдэс баялгийн салбараас төсөөт төвлөрүүлсэн орлого 1,187.7 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 734.1 тэрбум төгрөг буюу 38.2 хувиар буурсан байна. Төсөөт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- |                             |                                       |
|-----------------------------|---------------------------------------|
| ➤ Уул уурхай, олборлох      | 1,161.4 тэрбум төгрөг буюу 22.0 хувь, |
| ➤ Газрын тос                | 1.8 тэрбум төгрөг буюу 0.03 хувь,     |
| ➤ Тусгай зөвшөөрлийн төлбөр | 8.1 тэрбум төгрөг буюу 0.2 хувь,      |
| ➤ Бусад орлого              | 16.3 тэрбум төгрөг буюу 0.3 хувь.     |

<sup>1</sup> Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.

<sup>2</sup> Цайр нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно

<sup>3</sup> Хайлуур жонш нь МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

Эрдэс баяялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 22.5 хувийг бүрдүүлж байна.

### УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл / I-IV /		Гүйцэтгэл		
		2021 (Тодотгол)	2022	2021	2022	Өсөлт, бууралт	Хувь	
<b>Нийт орлогын дүн</b>		<b>4,795.9</b>	<b>4,615.9</b>	<b>1,921.8</b>	<b>1,187.7</b>	<b>-734.1</b>	<b>-38.2%</b>	
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР</b>								
<b>Нийт дүн</b>		<b>4,530.5</b>	<b>4,261.8</b>	<b>1,837.4</b>	<b>1,161.4</b>	<b>-675.9</b>	<b>-36.8%</b>	
1	Алт	183.8	235.7	42.3	57.5	15.2	35.9%	
2	Зэс	2,684.2	1,836.2	1,351.6	606.8	-744.8	-55.1%	
3	Нүүрс	1,287.8	1,594.0	321.8	427.3	105.6	32.8%	
4	Төмөр	97.8	200.1	45.1	18.4	-26.7	-59.2%	
5	Цайр	74.2	86.0	32.5	28.5	-3.9	-12.1%	
6	Хайлуур жонш	71.2	165.4	32.2	7.1	-25.1	-78.0%	
7	Бусад	131.5	144.5	11.9	15.8	3.9	32.8%	
<b>ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР</b>								
8	Газрын тос	213.2	277.5	65.7	1.8	-63.9	-97.3%	
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО</b>								
<b>Нийт дүн</b>		<b>52.2</b>	<b>76.6</b>	<b>18.7</b>	<b>24.5</b>	<b>5.8</b>	<b>30.8%</b>	
9	Тусгай зөвшөөрлийн төлбөр	31.2	31.4	7.2	8.1	0.9	12.4%	
10	ҮТ-ийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2.5	17.5	0.3	0.2	-0.0	-13.2%	
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/	16.0	25.0	9.8	14.1	4.3	44.2%	
12	Бусад орлого	2.5	2.7	1.4	2.0	0.6	41.9%	

Эх сурвалж: СЯ, АМГТГ

Тайлбар: 1 – дахин их

### 1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2022 оны эхний 4 сарын байдлаар улсын төсөвт 1,161.4 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 606.8 тэрбум төгрөг,
- Нүүрс 427.3 тэрбум төгрөг,
- Алт 57.5 тэрбум төгрөг,
- Цайр 28.5 тэрбум төгрөг,
- Төмөр 18.4 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 7.1 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 15.8 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 675.9 тэрбум төгрөг буюу 36.8 хувиар буурсан байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 105.6 (32.8%) тэрбум төгрөг,
- Алт 15.2 (35.9%) тэрбум төгрөг,
- Бусад 3.9 (32.8%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Зэс 744.8 (55.1%) тэрбум төгрөг,
- Төмөр 26.7 (59.2%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 25.1 (78.0%) тэрбум төгрөг,
- Цайр 3.9 (12.1%) тэрбум төгрөг.

## 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

### 2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

#### 2.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

2022 оны эхний 4 сарын байдлаар 6,416.4 мян.тн нүүрс, 364.3 мян.тн зэсийн баяжмал, 3,446.9 кг алт, 1,635.0 тн молибдены баяжмал, 2,535.2 мян.тн төмрийн хүдэр, 747.0 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 27.0 мян.тн хайлуур жоншны хүдэр, 4.3 мян.тн хайлуур жоншны баяжмал, 24.2 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмрийн хүдэр 243.7 мян.тн буюу 10.6 хувь, цайрын баяжмал 1.9 мян.тн буюу 8.5 хувиар тус тус өссөн байна.

Харин нүүрс 8,811.4 мян.тн буюу 57.9 хувь, алт 528.8 кг буюу 13.3 хувь, зэсийн баяжмал 89.1 мян.тн буюу 19.6 хувь, молибдены баяжмал 481.3 тн буюу 22.7 хувь, төмрийн хүдрийн баяжмал 435.9 мян.тн буюу 36.9 хувь, хайлуур жоншны хүдэр 13.8 мян.тн буюу 33.9 хувь, хайлуур жоншны баяжмал 12.4 мян.тн буюу 74.4 хувиар тус тус буурсан байна.

#### 2.1.2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2022 оны эхний 4 сарын байдлаар 61.8 мян.тн баяжуулсан нүүрс, 275.8 мян.тн нүүрсэн шахмал түлш, 3,152.0 тн катодын зэс, 3,140.2 тн металл бэлдэц, 4,076.0 тн металл цувимал, 1,396.1 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 1,722.9 мян.тн буюу 96.5 хувь, нүүрсэн шахмал түлш 113.4 мян.тн буюу 29.1 хувь, катодын зэс 81.3 тн буюу 2.5 хувь, металл бэлдэц 2,258.5 тн буюу 41.8 хувь, металл цувимал 1,039.2 тн буюу 20.3 хувь, ган төмөр хийц 220.9 тн буюу 13.7 хувиар тус тус буурсан байна.

#### 2.1.3. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

2022 оны эхний 4 сарын байдлаар 37.6 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,966.9 мян.бар буюу 98.1 хувиар буурсан байна.



## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2021		2022		Өөрчлөлт			
			IV	I-IV	IV	I-IV	(6-4)=?, (6/4)=%	(6-5)=?, (6/5)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>									
1.1	Нүүрс	мян.тн	2,836.3	15,227.8	1,330.1	6,416.4	-1,506.3	-53.1%	-8,811.4	-57.9%
1.2	Газрын тос	мян.тн	496.4	2,004.5	0.8	37.6	-495.5	-99.8%	-1,966.9	-98.1%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	111.6	453.4	92.9	364.3	-18.7	-16.8%	-89.1	-19.6%
1.4	Молибдений баяжмал, м/агуулгаараа	тн	570.1	2,116.3	616.2	1,635.0	46.1	8.1%	-481.3	-22.7%
1.5	Алт	кг	1,308.6	3,975.7	962.8	3,446.9	-345.8	-26.4%	-528.8	-13.3%
1.6	<b>Төмөр:</b>									
	- Төмрийн хүдэр	мян.тн	873.2	2,291.4	814.8	2,535.2	-58.4	-6.7%	243.7	10.6%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	424.6	1,182.9	254.6	747.0	-170.0	-40.0%	-435.9	-36.9%
1.7	<b>Хайлуур жонш:</b>									
	- Хайлуур жонш	мян.тн	7.3	40.7	7.7	27.0	0.5	6.6%	-13.8	-33.9%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	2.3	16.7	1.1	4.3	-1.2	-53.2%	-12.4	-74.4%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	1.6	22.3	6.2	24.2	4.6	291.6%	1.9	8.5%
2	<b>Боловсруулах аж үйлдвэр</b>									
2.1	<b>Хүнд үйлдвэр</b>									
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	378.1	1,784.7	40.8	61.8	-337.3	-89.2%	-1,722.9	-96.5%
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	53.3	389.2	19.6	275.8	-33.7	-63.2%	-113.4	-29.1%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	808.4	3,233.3	756.6	3,152.0	-51.8	-6.4%	-81.3	-2.5%
2.1.4	Металл бэлдэц	тн	1,797.3	5,398.7	7.3	3,140.2	-1,790.0	-99.6%	-2,258.5	-41.8%
2.1.5	Металл цувимал	тн	1,313.4	5,115.2	1,158.0	4,076.0	-155.4	-11.8%	-1,039.2	-20.3%
2.1.6	Ган төмөр хийц	тн	409.7	1,617.0	338.2	1,396.1	-71.5	-17.5%	-220.9	-13.7%

Эх сурвалж: УСХ

Тайлбар: 1 - дахин их

## 2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

№	Салбар	2021		2022		Өөрчлөлт	
		IV	I-IV	IV	I-IV	(5-3)=?, (5/3)=%	
	1	2	3	4	5	6	7
	<b>Нийт дүн</b>	<b>1,506.2</b>	<b>6,188.3</b>	<b>1,355.9</b>	<b>4,926.3</b>	<b>-1,261.9</b>	<b>-20.4%</b>
<b>1</b>	<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>	<b>1,070.3</b>	<b>4,448.9</b>	<b>869.5</b>	<b>3,101.3</b>	<b>-1,347.7</b>	<b>-30.3%</b>
1.1	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	261.2	1,673.6	145.7	526.4	-1,147.3	-68.5%
1.2	Газрын тос олборлолт	79.2	303.7	0.3	10.7	-293.0	-96.5%
1.3	Металлын хүдэр олборлолт	711.0	2,405.4	705.0	2,510.5	105.0	4.4%
1.4	Бусад ашигт малтмал олборлолт	16.4	57.0	14.9	46.2	-10.8	-19.0%
1.5	Уул уурхайн туслах үйл ажиллагаа	2.4	9.2	3.7	7.6	-1.7	-18.1%
<b>2</b>	<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>304.6</b>	<b>1,163.1</b>	<b>343.3</b>	<b>1,201.4</b>	<b>38.3</b>	<b>3.3%</b>
<b>2.1</b>	<b>Хүнд үйлдвэр</b>	<b>54.2</b>	<b>227.4</b>	<b>77.7</b>	<b>225.5</b>	<b>-1.9</b>	<b>-0.8%</b>
2.1.1	Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.0	58.8	2.9	41.3	-17.5	-29.8%
2.1.2	Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7.8	40.6	6.1	19.5	-21.1	-52.0%
2.1.3	Тэмэрлэг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	18.0	53.3	38.6	69.3	16.0	30.0%
2.1.4	Металл боловсруулах үйлдвэрлэл	19.9	71.7	29.0	92.1	20.4	28.4%
2.1.5	Машин, тоног төхөөрөмжкөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.3	1.6	0.7	2.2	0.5	32.9%
2.1.6	Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.3	1.4	0.4	1.2	-0.2	-13.7%

Эх сурвалж: УСХ

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 оны эхний 4 сарын байдлаар 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (20.4%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 3.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (30.3%) их наяд төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.1 (68.5%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 293.0 (96.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Харин металлын хүдэр олборлолт 105.0 (4.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 63.0 хувийг эзэлж байна.

## 2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

№	Салбар	2021		2022			Тэрбум төгрөг	
		IV	I-IV	IV	I-IV	Гадаадад	(4-2)=?, (4/2)=%	
		1	2	3	4	5	6	7
	Нийт дүн	1,675.0	8,103.3	1,596.4	6,548.1	3,709.5	-1,555.2	-19.2%
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,158.4	5,983.5	1,016.3	4,387.2	3,579.5	-1,596.3	-26.7%
1.1	Чулуун, хүрэн нүүрс олборлолт	309.6	2,010.4	253.0	953.6	812.9	-1,056.8	-52.6%
1.2	Газрын тосны олборлолт	74.7	285.9				-285.9	-100.0%
1.3	Металлын хүдэр олборлолт	745.1	3,581.1	745.1	3,392.9	2,751.1	-188.3	-5.3%
1.4	Бусад ашигт малтмал олборлолт	26.6	97.7	14.8	33.5	15.5	-64.3	-65.8%
1.5	Уул уурхайн туслах үйл ажиллагаа	2.4	8.3	3.4	7.3	-	-1.1	-13.1%
2	Боловсруулах аж үйлдвэр	384.5	1,541.1	436.3	1,535.8	130.1	-5.2	-0.3%
2.1	Хүнд үйлдвэр	84.0	378.0	116.9	282.8	66.0	-95.2	-25.2%
2.1.1	Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7.0	53.5	1.4	38.4		-15.1	-28.3%
2.1.2	Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.8	44.6	9.1	32.3		-12.3	-27.7%
2.1.3	Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	24.1	65.6	52.6	91.9		26.3	40.0%
2.1.4	Металл боловсруулах үйлдвэрлэл	43.2	210.9	52.9	116.9	65.9	-94.1	-44.6%
2.1.5	Машин, тоног төхөөрөмжкөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.6	1.8	0.6	2.2	0.0	0.3	17.4%
2.1.6	Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	0.3	1.4	0.4	1.2		-0.2	-15.5%

Эх сурвалж: УСХ

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2022 оны эхний 4 сарын байдлаар 6.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (19.2%) их наяд төгрөгөөр буурсан байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (26.7%) их наяд төгрөгөөр буурахад чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбарын борлуулалт 1.1 (52.6%) их наяд төгрөг, металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 188.3 (5.3%) тэрбум төгрөг, газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 285.9 (100.0%) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолтын салбарын борлуулалт 64.3 (65.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлөв.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 3.7 их наяд төгрөг буюу 56.7 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 3.6 их наяд төгрөг буюу 96.5 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

### 3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2022 оны эхний 4 сарын байдлаар 5,148.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 690.8 сая ам.доллар буюу 15.5 хувиар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 450.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

#### 3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2022 оны эхний 4 сарын байдлаар 2,799.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 302.7 сая ам.доллар буюу 12.1 хувиар өссөн байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2,682.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 411.3 сая ам.доллар буюу 18.1 хувиар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 95.8 хувийг эзэлж байна.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2021	2022	Өөрчлөлт	
		I-IV	+/-	Хувь	
Чулуун нүүрс	тн/ам.дол	103.7	280.7	177.0	2.7 <sup>1</sup>
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,980.5	2,152.8	172.3	8.7%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	128.6	100.4	-28.2	-21.9%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,515.6	1,967.7	452.2	29.8%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	213.0	242.9	29.8	14.0%
Молибдены баяжмал	тн/ам.дол	7,983.8	14,244.1	6,260.3	78.4%

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

##### 3.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

Чулуун нүүрсний экспорт: 2022 оны эхний 4 сарын байдлаар 1,064.4 сая ам.долларын 3,791.4 мян.тн чулуун нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 305.8 сая ам.доллар буюу 40.3 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 3,521.5 мян.тн буюу 48.2 хувиар буурсан байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 280.7 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 177.0 ам.доллар буюу 2.7 дахин өссөн байна. Чулуун нүүрсний 90.9 хувийг БНХАУ, 7.2 хувийг Сингапур Улс, 1.7 хувийг БНСҮ, 0.2 хувийг Хонгонк улсруу тус тус экспортолсон байна.

**Зэсийн баяжмалын экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 1,010.2 сая ам.долларын 469.3 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 236.2 сая ам.доллар буюу 30.5 хувиар, биет хэмжээгээр 78.5 мян.тн буюу 20.1 хувиар тус тус өссөн байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 2,152.8 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 172.3 ам.доллар буюу 8.7 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Төмрийн хүдэр, баяжмалын экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 102.1 сая ам.долларын 1,017.4 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 234.2 сая ам.доллар буюу 69.6 хувиар, биет хэмжээгээр 1,597.7 мян.тн буюу 61.1 хувиар тус тус буурсан байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 100.4 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 28.2 ам.доллар буюу 21.9 хувиар буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 18.8 сая ам.долларын 77.4 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 179.4 мян.тн буюу 69.9 хувиар, үнийн дүнгээр 35.9 сая ам.доллар буюу 65.6 хувиар тус тус буурсан байна. 1 тн хайлуур жоншны экспортын дундаж үнэ 242.9 ам.доллар болж, 29.8 ам.доллар буюу 14.0 хувиар өссөн байна. Хайлуур жоншны 80.5 хувийг ОХУ, 19.5 хувийг БНХАУ руу тус тус экспортолсон байна.

**Цайрын баяжмалын экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 80.0 сая ам.долларын 40.6 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2.3 мян.тн буюу 5.4 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 14.8 сая ам.доллар буюу 22.8 хувиар өссөн байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,967.7 ам.доллар болж, 452.2 ам.доллар буюу 29.8 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Молибдены баяжмалын экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 23.7 сая ам.долларын 1,664.0 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 6.2 сая ам.доллар буюу 35.1 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 532.8 тн буюу 24.3 хувиар буурсан байна. 1 тн молибдены баяжмалын экспортын дундаж үнэ 14,244.1 ам.доллар болж, 6,260.3 ам.доллар буюу 78.4 хувиар өссөн байна. Молибдены баяжмалын 90.7 хувийг БНХАУ, 9.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

**Алтны экспорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 326.9 сая ам.долларын 5,443.0 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 276.8 сая ам.доллар буюу 6.5 дахин, биет хэмжээгээр 4,562.6 кг буюу 6.2 дахин тус тус өссөн байна. 1 кг алтны экспортын дундаж үнэ 60,059.0 ам.доллар болж, 3,132.9 ам.доллар буюу 5.5 хувиар өссөн байна. Алтны 100 хувийг Швейцар руу экспортолсон байна.

### 3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Газрын тосны экспорт: 2022 оны эхний 4 сарын байдлаар газрын тос экспортлоогүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 1,890.2 мян.бар буюу 100 хувиар, үнийн дүнгээр 105.8 сая ам.доллар буюу 100 хувиар тус тус буурсан байна.

### 3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Коксын экспорт: 2022 оны эхний 4 сарын байдлаар кокс экспортлоогүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 8.4 сая ам.доллар буюу 100 хувиар, биет хэмжээгээр 32.3 мян.тн буюу 100 хувиар тус тус буурсан байна.

Катодын зэс: 2022 оны эхний 4 сарын байдлаар 20.9 сая ам.долларын 2,122.0 тн катодын зэс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 2,121.1 тн буюу 50.0 хувиар, үнийн дүнгээр 15.5 сая ам.доллар буюу 42.6 хувиар тус тус буурсан байна. 1 тн катодын зэсийн экспортын дундаж үнэ 9,848.5 ам.доллар болж, 1,271.0 ам.доллар буюу 14.8 хувиар өссөн байна. Катодын зэсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

### 3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2022 оны эхний 4 сарын байдлаар 2,349.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 388.1 сая ам.доллар буюу 19.8 хувиар өссөн байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 505.3 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 141.1 сая ам.доллар буюу 38.7 хувиар өссөн байна.

#### ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

Барааны нэр	Хэмжих нэгж	2021	2022	Өөрчлөлт	
		I-IV		+/-	Хувь
Автобензин	тн/ам.дол	518.8	827.9	309.1	59.6%
Дизель түлш	тн/ам.дол	507.3	796.1	288.8	56.9%

Эх сурвалж: ГЕГ

#### 3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 85.7 хувиийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2022 оны эхний 4 сарын байдлаар 433.0 сая ам.долларын 523.1 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 51.0 мян.тн буюу 8.9 хувиар буурсан ч, үнийн дүнгээр 130.0 сая ам.доллар буюу 42.9 хувиар өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 89.7 хувиийг автобензин, дизель түлшний импорт, үүний 40.6 хувиийг автобензин, 49.1 хувиийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

**Автобензины импорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 175.7 сая ам.долларын 212.2 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 76.2 мян.тн буюу 56.0 хувиар, үнийн дүнгээр 105.1 сая ам.доллар буюу 2.5 дахин тус тус өссөн байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 827.9 ам.доллар болж, 309.1 ам.доллар буюу 59.6 хувиар өссөн байна.

**Дизель түлшний импорт:** 2022 оны эхний 4 сарын байдлаар 212.8 сая ам.долларын 267.3 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 33.8 сая ам.доллар буюу 18.9 хувиар өссөн ч, биет хэмжээгээр 85.5 мян.тн буюу 24.2 хувиар буурсан байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 796.1 ам.доллар болж, 288.8 ам.доллар буюу 56.9 хувиар өссөн байна.